

Боловсролын салбарын хяналт хариуцсан шинжээч, Дашпунцаг Өнөржаргал
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Боловсролын хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, санал өгөх, хэрэгжилтийг хангуулахад мэргэжил арга зүйгээр хангах							
1	Боловсролын хууль тогтоомж, дүрэм журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэх хяналтын хуудсыг боловсруулж батлуулах	Хяналтын хуудас боловсруулж батлуулсан байна.	6	-	2024 онд №03/6.1-1.” Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”, № 03/6.1-2 кодтой “Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг шалгах” хяналтын хуудас, №03/6.1-3. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, № 03/6.1-4. Дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, 03/6.1-5.	3-р сар, 4-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын дотуур байрны үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, №03/6.1-6. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байрны үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас боловсруулж, БШУ-ны сайдын 2024-04-02-ны өдрийн А/150 дугаар тушаалаар шинэчлэн батлууллаа. Шинээр батлагдсан хяналтын хуудсанд Боловсролын багц хуултд шинээр оруулсан асуултуудыг тусгаж, биелэлтийг хангуулан ажиллаж байна. Хавсралт: 6 файл		
1.2. Иргэний сурч боловсрох эрх, тэгш боломж, чанартай боловсрол эзэмших, эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг хангуулах, салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн баталсан нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бэхжүүлэх							
2	Ерөнхий боловсролын сургууль болон дээд боловсролын сургалтын байгууллагын орчны стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт	Стандартын хэрэгжилтийн хувь Илэрсэн зөрчлийн эзлэх хувь	Стандартын хэрэгжилтийн хувь - 47.5% Илэрсэн зөрчлийн эзлэх хувь - 33,4%	Стандартын хэрэгжилтийн хувь - 52,5% Илэрсэн зөрчлийн эзлэх хувь - 28,4%	Ерөнхий боловсролын сургууль болон дээд боловсролын сургалтын орчинд төлөвлөгөөт хяналт шалгалтад 415 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, 93,7 хувийн гүйцэтгэлтэй. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн 47 хувь боловсролын сургалтын	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 85% Нэгжийн даргын үнэлгээ

	хийнэ				байгууллагын орчинд тавигдах шаардлага, стандарт хэрэгжээгүй зөрчлүүд байна. Зөрчил арилгуулах хугацаатай үүрэг өгч, хөрөнгө санхүүтэй холбоотойтоогоор зөрчил бүрэн арилахгүй байна. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын орчны стандартад хяналтын хуудсаар үнэлгээг хийхэд улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн 42 хувьд гадаад орчин биеийн тамир, туршилтын талбай, камертай байх шаардлагууд хэрэгжихгүй байна. Иймд 2025 онд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын орчинд стандартын шаардлага хангалтаар эрэмбэлэхээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалт төлөвлөлөө. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулиар сонсголын бэрхшээлтэй суралцагчдад сургалтын дохионы хэлтэй байх, суралцах орчин, сурах бичгээр хангах зохицуулалтыг шинээр тусгаж өгсөн.		төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
3	Эрсдэлийн үнэлгээ, хяналтын хуудасны бүртгэл, мэдээллийн	Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн	Мэдээллийн сан - 0 Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн - 5	Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн	2024 онд 1785 объектод эрсдэлийн үнэлгээ хийхэд 183 нь их, 1228 дунд, 374 объект бага эрсдэлтэй	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн

	нэгдсэн сан хөтлөх, хяналт шалгалт хэрэгжүүлэх доод шатны нэгж, улсын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллана.	нэгдсэн сангийн баяжуулалт (тоо) Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо Хамрагдсан улсын байцаагчийн тоо	Хамрагдсан улсын байцаагч - 60	нэгдсэн сан хөтөлсөн байна. Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо - 6 Хамрагдсан улсын байцаагч - 70	үнэлэгдэж, их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 355 объектод 2025 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх, урьдчилан сэргийлэх 5 хяналт шалгалт, Дундговь, Сүхбаатар аймгуудад бусад яамдын салбарын хяналтын газартай хамтарсан хяналт шалгалт хийх төлөвлөгөөний төслийг 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр 11/1849 дугаартай албан бичгээр Хяналт, үнэлгээний үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны даргад хүргүүлээ. Шинээр томилогдсон Булган, Дундговь, Сүхбаатар, Баянхонгор аймгийн Боловсролын газрын улсын байцаагчдад эрсдэл үнэлэх чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, бусад аймаг, нийслэлийн улсын байцаагчдад шилэн хяналтын систем шинэчлэгдэж байгаатай холбоотой мэдээлэл өгч, арга зүйгээр хангаж, бүртгэлд хяналт тавьж байна.	5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
4	Боловсролын багц хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журам,	Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо	Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо - 15	Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо - 20	-Хүүхдийн хөгжил хамгааллын стандартчиллын техникийн хорооны гишүүнээр ажиллаж, MNS:....2024,	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын

	стандартын хэрэгжилтийг хангуулах, дүрэм журам, стандартыг боловсронгуй болгох санал өгнө.			“Хүчирхийллийн хохирогч хүүхдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх нийтлэг шаардлага” стандарт, “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих шаардлага”, “Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ, түүнийг үзүүлэх байгууллагад тавих нийтлэг шаардлага”, “Хүчирхийллийн хохирогч хүүхдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх нийтлэг шаардлага” стандартын төслийн хэлэлцүүлэгт 2024 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр оролцож, санал өгч, хамтарч ажиллалаа. - “Хүүхдийн цэцэрлэгийн багш, удирдах ажилтанд мэргэжшлийн зэрэг олгох, хүчингүй болгох”, “Төрөлжсөн сургалт зохион байгуулах”, “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын төсөлд санал өглөө. - “Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлага” ГБХНХ-ын сайд, Боловсролын садын хамтран батлах тушаалын төсөлд санал өглөө. Хавсралт: 5 файл	9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ: 98% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	---	--	--	--	--	---

5	Их буюу дунд эрсдэлтэй үнэлэгдсэн боловсролын сургалтын байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх	Шалгалт хийсэн объектын тоо Зөрчил арилгуулалтын хувь Хууль сахин мөрдөлтийн түвшин	Шалгалт хийсэн объектын тоо - 390 Зөрчил арилгуулалтын хувь - 73% Хууль сахин мөрдөлтийн түвшин - 75%	Шалгалт хийсэн объектын тоо - 342 Зөрчил арилгуулалтын хувь - 83% Хууль сахин мөрдөлтийн түвшин - 85%	2024 онд 342 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөж, БШУ-ны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/15 дугаар тушаалаар баталж, олон нийтэд ил болгож, яамны "хяналт шалгалт" цэсэнд байршуулсан. "Боловсролын сургалтын байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх" удирдамж 2024 оны 02 дугаар сарын 19-ны өдөр ЭМЯ-ны салбарын хяналтын газрын дарга, улсын ерөнхий байцаагчтай хамтран баталсан 03-00/03 дугаартай удирдамж баталсан. Хяналт шалгалтыг аймаг, нийслэлд 03 дугаар сарын 01-нээс 11 дүгээр сарын 25 хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэж, хяналт шалгалтын дүнг нэгтгэж, шилэн хяналтын системд бүртгэж байна. Хяналт шалгалтад хамрагдалт 96,4 хувийн гүйцэтгэлтэй. Өвөрхангай, Дундговь аймгуудад улсын байцаагчгүй болон чөлөөтэй байсан шалтгаанаар хяналт шалгалт хийгдээгүй, бусад аймаг нийслэлд төлөвлөсөн объект бүрэн хамрагдлаа. Эрсдэл буурсан объектын тоо-60, эрсдэл буураагүй	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 98% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
---	---	---	---	---	--	---	---

					объектын тоо-17 байна. Бага эрсдэлтэй үнэлэгдсэн-12%, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн-71%, их эрсдэлтэй үнэлэгдсэн-17 % байна.		
6	Хэнтий аймгийн Боловсролын газар болон их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт хийх	Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо Зөрчил арилгуулалтын хувь Хууль сахин мөрдөлтийн түвшин	-	-	Хяналт шалгалтыг 2024 оны 05 дугаар сарын 24-ны өдрөөс ажлын 7 хоногт Боловсролын яамны Салбарын хяналтын газрын дарга, салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 03-00/20 дугаартай удирдамжаар хяналт шалгалт хийлээ. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг газрын дарга Л.Төгсбаяр ахалж, боловсрол, шинжлэх ухааны хяналтын улсын ахлах байцаагч Д.Өнөржаргал, боловсрол, шинжлэх ухааны хяналтын улсын ахлах байцаагч Д.Батсүх, боловсрол, шинжлэх ухааны хяналтын улсын ахлах байцаагч А.Мөнх-Эрдэнэ нар хийж гүйцэтгэлээ. Хяналт шалгалтад Хэнтий аймгийн Өндөрхаан сумын ерөнхий боловсролын 5-р сургууль, 8-р цэцэрлэг, Политехник коллеж, Норовлин, Дадал, Баян-Адарга сумын цэцэрлэг, сургууль, дотуур байр	4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хамрагдлаа. хяналт шалгалтаар сургуулийн менежмент, төлөвлөлт, сургалтын чанарт гарч байгаа өөрчлөлтөд нөлөөлж байгаа хүчин зүйлийг тооцох, цахим сургалт зохион байгуулах орчин нөхцөл бүрдээгүй, лаборатори дадлагын газарт хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлага хангаагүй нийтлэг зөрчлүүд илэрч, Дадал сумын цэцэрлэг, сургуульд албан шаардлага өгч, биелэлтэд хяналт тавьсан. Баян-Адрага сумын цэцэрлэг, сургууль, дотуур байр бага эрсдэлтэй, бусад нь дунд эрсдэлтэй үнэлэгдсэн байна.		
7	Түрээсийн байртай цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоо Илэрсэн зөрчил арилгуулалтын хувь	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоо - 133 Илэрсэн зөрчил арилгуулалтын хувь - 55,5%	-	Түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал, эрүүл ахуй, хоол үйлдвэрлэлийн нөхцөлд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх БШУЯ/хуучин нэрээр/, ЭМЯ-ны Салбарын хяналтын газрын дарга, улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 02 дугаар сарын 19-ны өдөр баталсан 03-00/02 дугаартай удирдамжаар 2024 оны 02	2-р сар, 3-р сар, 4-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					дугаар сарын 20-ны өдрөөс 04 дүгээр сарын 22-ны өдрүүдэд боловсрол, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын /ахлах/ байцаагчид хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтад 7 дүүрэг, 9 аймгийн 119 цэцэрлэг, 6 дүүрэг, 7 аймгийн 36 ерөнхий боловсролын сургууль хамрагдлаа. Хяналт шалгалтаар түрээслэсэн байрууд зориулалтын бус, гал тогоо, номын сан, биеийн тамирын талбай, хүүхдэд зориулсан ариун цэврийн өрөөгүй, камержуулалтгүй, цэцэрлэгийн салбар бүлгүүд нэмэгдсэнээр эрхлэгч, арга зүйчийн ажлын ачаалал нэмэгдсэн зэрэг нийтлэг 98 зөрчил илэрч, 58 буюу 65,6 хувийг шалгалтын явцад арилгалаа. Цаашид зориулалтын бус байранд сургалтын үйл ажиллагаа явуулахад мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах шаардлагатай байна.		
8	Элсэлтийн ерөнхий шалгалт зохион байгуулах үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт	Зөрчил арилгуулалтын хувь	Зөрчил арилгуулалтын хувь - 60%	-	Боловсрол, шинжлэх ухааны яамны /хуучин нэрээр/ Салбарын хяналтын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдөр баталсан 03-00/27	6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын

	шалгалт хийх				дугаартай удирдамжаар элсэлтийн шалгалтын явц, зохион байгуулалтад Боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн Боловсролын газрын боловсролын хяналтын улсын /ахлах/ байцаагч нар 2024 оны 07-р сарын 04-07 ны өдрүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийлээ.Улсын хэмжээнд 2024 оны 07 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд элсэлтийн шалгалт амжилттай зохион байгууллаа. Орон нутагт элсэлтийн шалгалттай холбоотой Сэлэнгэ, Орхон, Дорноговь, Завхан аймагт шалгуулагчаас гаргасан 8 гомдлыг газар дээр нь шийдвэрлэсэн байна. Хяналт шалгалтаар харандаа болон үзүүрлэгч баллуур чанаргүй, шууд засалтын төхөөрөмж саатах, шалгалтын байруудын ариун цэврийн байгууламжийг бүрэн ажиллагаанд оруулаагүй зөрчлүүдийг арилгуулсан байна.Зөрчил арилгуулалт-70 хувьтай. Өмнөх оноос 5 пунктээр өссөн байна. Элсэлтийн шалгалт өгөхөөр 35939 суралцагч бүртгүүлж, 14812 нь нийслэл, 17541 нь	үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--------------	--	--	--	---	---

					орон нутгийн шалгуулагчид, өмнөх оны 3586 шалгуулагч байлаа. Улсын хэмжээнд 38 тусгай хэрэгцээт шалгуулагч шалгалт өгсөн байна. Хавсралт: 1 файл		
9	Бүх шатны боловсролын сургалтын байгууллагуудын 2024-2025 оны хичээлийн жилийн бэлтгэл ажилд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Зөрчил арилгуулалтын хувь	Зөрчил арилгуулалтын хувь - 53,5%	Зөрчил арилгуулалтын хувь - 70%	БШУЯ, ЭМЯ, ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газрын дарга, улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 03 дугаар сарын 12-ний өдөр баталсан 03/00/13 дугаартай удирдамжийн дагуу аймаг, нийслэлийн 276 цэцэрлэг, 438 ерөнхий боловсролын сургууль буюу улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийт боловсролын сургалтын байгууллагын 18,4 хувийг хамрууллаа. Хяналт шалгалтаар шалгалтад хамрагдсан цэцэрлэг, сургуулийн 11,3 хувь нь камержуулалтгүй, 16,5 хувь нь хүүхдийн онцлог ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд боловсрол эзэмшүүлэх орчин бүрдүүлээгүй, 46,4 хувь нь гадна тоглоом, биеийн тамирын талбай, тоног төхөөрөмжгүй, 21 хувьд хүүхэд хамгааллын баг ажиллуулах төлөвлөгөөгүй, 10,3 хувьд эзэмшил газар хамгаалсан хашаа хайсгүй, 187	8-р сар, 9-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					мэргэжлийн багш дутагдалтай 1147 зөрчил дутагдал илэрч, 561 буюу 48,9 хувийг шалгалтын явцад арилгаж, зөрчил дутагдал арилгуулахаар 64 байгууллагад 377 заалттай албан шаардлага, 12 байгууллагад 78 заалттай албан даалгавар хүргүүлж, зөрчил дутагдал арилгаагүй сургуулиудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөлөө. Зөрчил арилгуулалт-74 хувьтай.		
10	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь Зөрчил арилгуулалтын хувь	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь - 90% Зөрчил арилгуулалтын хувь - 95%	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь - 90% Зөрчил арилгуулалтын хувь - 70%	Боловсролын сайдын өгсөн үүрэг чиглэлийн дагуу аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай 18 ерөнхий боловсролын сургуульд 2024 оны 11 дүгээр сарын 21-30-ны өдрүүдэд хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтын дүнг нэгтгэж байна. -Иргэний гомдлоор Булган аймгийн 1, 2, 3 дугаар сургууль, Спортын сургуульд 2024 оны 10 дугаар сарын 07-11-ний өдрүүдэд хяналт шалгалт хийж, 3555 суралцагчийн баримт бичиг шалгаж, 3 дугаар сургуульд зөрчил дутагдал арилгуулах албан шаардлага өгч, 2 албан тушаалтанд торгуулийн арга хэмжээ авч, хувийн хэрэгт	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хуурамчаар бүрдүүлсэн, ашигласан захирлыг шалгуулахаар аймгийн Цагдаагийн газарт шилжүүллээ. -Улсын ерөнхий байцаагчаас өгсөн үүргийн дагуу НБГ-ын СХХ-ийн үйл ажиллагаанд 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 15-ны өдрүүдэд улсын байцаагчийн үйлдсэн баримт бичиг ТХШТХ болон холбогдох дүрэм журамд нийцэж байгаа эсэхийг шалгаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. -Иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу “Найтын Австрали-Монгол” сургуульд 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр хяналт шалгалт хийж, Зөрчлийн тухай хуулийн 9.1.5 дахь заалтаар 2 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан. - Иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу ерөнхий боловсролын “Ес эрдэм” сургууль 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хийж, албан шаардлага өгч, биелэлтийг хангуулсан. - Иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу “Тэмүүжин- Өрлөг” сургуульд 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр шалгалт хийж, 2 суралцагчийг хуулт бус хассан зөрчлийг арилгуулж, үргэлжлүүлэн суралцуулсан.		
--	--	--	--	--	--	--	--

					-Иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу Олонлог академи сургууль 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр шалгаж, хассан суралцагчийг буцаан суралцуулсан. -ГХЯны албан бичгийн дагуу ХУИС-д 2024 оны 06 дугаар сарын 24 өдөр шалгаж, Цагдаад шилжүүлсэн. -БШУ-ны сайдаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу Олон улсын хөтөлбөртэй 22 сургуульд 2024 оны 04 дүгээр сарын 25-30-ны өдрүүдэд шалгалт хийсэн. Хавсралт: 7 файл		
11	Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх	Албан шаардлагын тоо - Зөрчил арилгуулалтын хувь	Албан шаардлагын тоо - 243 Зөрчил арилгуулалтын хувь - 44%	Албан шаардлагын тоо - 150 Зөрчил арилгуулалтын хувь - 60%	-Булган аймгийн 3 дугаар сургуульд өгсөн албан шаардлага -Тэмүүжин-Өрлөгт өгсөн албан шаардлага -Хүмүүнлэгийн ухааны их сургуульд өгсөн албан шаардлага - Найти Австрали сургуульд өгсөн албан даалгавар -БЕГ-т хүргүүлсэн хариуцлага тооцуулах албан бичиг Хавсралт: 14 файл	9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
3.1. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд оруулж тайлагнах							
12	Холбогдох хууль тогтоомж, тогтоол	Хууль, тогтоомж, тогтоол	2023 оны биелэлтийн хувь	Холбогдох заалтын	2024 онд их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 342 объектод	1-р сар, 2-р сар,	Өөрийн

	шийдвэрийн биелэлтийг тайлагнах.	шийдвэрийн тоо		хэрэгжилт хангагдсан байна.	төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, 6 хяналтын хуудсаар Боловсролын багц хууль, шинээр батлагдсан тушаал, дүрэм журмын хэрэгжилтийг шалгахад Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 69 хувь, ерөнхий боловсролын сургуульд 63 хувь, Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарт 64 хувь, их дээд сургуульд 68 хувийн хэрэгжилттэй. Боловсролын хяналтын чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилт 66 хувьтай байна. Хэрэгжилтийг ангилж үзэхэд боловсролын сургалтын байгууллагын удирдлага зохион байгуулалт-12,1 хувь, сургалтын гадаад дотоод орчны стандарт-40 хувь, багшлах боловсон хүчин, хүний нөөц-22 хувь, сургалтын хөтөлбөр төлөвлөгөө 11,2 хувьд хэрэгжээгүй байна.	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
13	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, гүйцэтгэлийг тайлагнах	Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулсан, Хэрэгжилтийг тайлагнасан байна.	Гүйцэтгэлийн төлөвлөгөө - 1 Тайлагналт - 12	Тайлагналт - 12	2024 онд бодлогын баримт бичиг болон хуулиар тусгайлан олгосон чиг үүрэгт 2 зорилтын хүрээнд 11 ажил, хуулиар олгосон нийтлэг чиг үүрэг 2 зорилтын хүрээнд 5 ажил, мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын хүрээнд 2 ажил төлөвлөж, төлөвлөсөн ажлын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ

					гүйцэтгэлийг сар, улирал, хагас жилээр тайлагнаж байна, Хагас жилээр хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээг нэгжийн дарга болон хамт олноор үнэлүүлээ.	11-р сар, 12-р сар	төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
14	Цаг үеийн нөхцөл шаардлагаар хийж хэрэгжүүлэх ажил үйлчилгээг гүйцэтгэх	Хэрэгжүүлсэн арга хэмжээ Гүйцэтгэлийн хувь	-	Хэрэгжүүлсэн арга хэмжээ – 100 Гүйцэтгэлийн хувь - 100%	-ХНХ-ын сайдын баталсан 2024 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн А/01 дүгээр удирдамжаар "Монголын Бурхан шашинтны төв Гандантэгчлэн хийдэд суралцаж буй хүүхдийн эрхийн хэрэгжилттэй танилцах удирдамжийн дагуу 6 дацанд байрлах өрөө, дотуур байранд хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хүүхэд хамгааллын чиглэлээр боловсруулах эрх зүйн актуудад саналаа өгсөн. -2024 оны 06 дугаар сарын 10-нд улсын хэмжээнд боловсролын хяналтын улсын байцаагчдад зориулж, "Төрийн хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалт зохион байгууллаа. - Монгол Улсын Онцгой комиссын даргын 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 01 дүгээр тушаал, Улсын Онцгой	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					комиссын нарийн бичгийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Хяналт шалгалт удирдамж”-ийн дагуу хяналт шалгалтыг 2024 оны 2 дугаар сарын 05-ны өдрөөс 03 дугаар сарын 15-ны өдөр хүртэл нийслэл үйл ажиллагаа явуулж байгаа шатахуун түгээх станц, газрын тосны бүтээгдэхүүний агуулах/ГТБА/, авто хийгээр цэнэглэх станц/АХЦС/-д хяналт шалгалт хийх ажлын хэсэгт ажиллалаа. Шалгалтад 29 шатахуун түгээх станцын 263 хошуу, газрын тосны бүтээгдэхүүний агуулах/ГТБА/-1, авто хийгээр цэнэглэх станц/-12 буюу 13 аж ахуйн нэгж шалгалтад хамрагдаж, зөрчилтэй-63 объект байна. Дүн холбогдох арга хэмжээ авах саналыг Улсын Онцгой комиссын нарийн бичгийн даргад танилцууллаа. Хавсралт: 2 файл		
15	Хяналт шалгалтын төлөвлөгөөний төсөл болон 2025 онд хяналт шалгалтад хамрагдах объектын	Хуулийн хугацаанд хүргүүлсэн байна.	1	1	Хяналт, үнэлгээний хороонд 2025 онд хяналт шалгалт хийх төлөвлөгөөний төслийг 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр 11/1849 дугаартай албан бичгээр, Хяналт шалгалтын	10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

	жагсаалтыг гаргаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх				төлөвлөгөөний төсөл, 2025 онд хяналт шалгалтад хамрагдах 355 объектын жагсаалтыг 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлсэн. 2025 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах 355 объектын 269 буюу 75 хувь дунд, 56 буюу 25 хувь их эрсдэлтэй үнэлэгдсэн объект байна. Байршлын хувьд 132 буюу 37 хувь, 223 буюу 63 хувь байна. Дундговь, Сүхбаатар аймагт бусад яамдын Салбарын хяналтын газартай хамтарч төлөвлөгөөт хяналт шалгалт хийх, урьдчилан сэргийлэх 4 хяналт шалгалт хийх төлөвлөгөөний төсөл боловсруулж хүргүүлсэн. Хавсралт: 2 файл		Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	--	--	--	---	--	--

3.2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах

16	Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын мэдээлэл, хяналтын хуудсыг олон нийтэд нээлттэй байршуулах, хяналт шалгалтын талаарх	Мэдээллийн тоо, хэрэгжилтийн хувь	2023 оны байршсан мэдээлэл	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн	2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт болон боловсролын чиглэлээр хяналт шалгалт хийх 6 хяналтын хуудас Боловсролын яамны "Ил тод-хяналт шалгалт" цэсэнд байршуулсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ
----	--	-----------------------------------	----------------------------	--	---	--	--

	шаардлагатай мэдээллийг ил тод болгох			байршуулсан байна.	Хавсралт: 3 файл		төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	---------------------------------------	--	--	--------------------	------------------	--	---

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Төрийн албаны болон салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн шинээр болон шинэчлэн батлагдсан дүрэм журмыг уншиж судлах	Шинээр болон шинэчлэгдэн батлагдсан хууль, эрх зүйн баримт бичгүүдийг тухай бүр уншиж, судлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ.	-	Албан хаагчийн хууль эрх зүйн мэдлэг сайжирсан байна.	-ТЗУГ-аас зохион байгуулсан " монгол бичгийн хэрэглээ" хичээлд 7 хоног бүр хамрагдаж байна. Мөн байгууллагаас зохион байгуулж байгаа мэдээллийн цагт хамрагдаж байна. -Сайдын 2024 оны А/25 дугаар тушаал "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг дэв олгох, хүчингүй болгох журам"-тай танилцлаа. -Төрийн албаны тусгай шалгалт өгч, шинжээчээр томилогдлоо. Төрийн албаны тухай хууль тогтоомж, тест,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 98%

					асуудал шийдвэрлэх, дүн шинжилгээ хийх чиглэлээр холбогдох материалуудыг уншиж судаллаа. Байгууллагаас 14 хоног тутамд мэдээллийн цагт Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж байгаа сургалтуудад хамрагдаж байна.		
2	Мэргэжил, боловсролоо дээшлүүлэх чиглэлээр танхимын болон цахим сургалтуудад хамрагдана.	Яам болон холбогдох газруудаас зохион байгуулсан цахим болон танхимын сургалтад хамрагдана.	-	Албан хаагчийн мэргэжлийн ур чадвар дээшилсэн байна.	Яамны 14 хоног тутмын мэдээллийн цагт хамрагдаж байна. 2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдөр Удирдлагын академийн Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад хамрагдаж, 11 багц цагийг дүүргэсэн. Хавсралт: 2 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Боловсролын салбарын хяналт хариуцсан шинжээч, Дашпунцаг Өнөржаргал /...../

Огноо:

.....